



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/35

Дэлгэрхаан сум

Мал амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны сэг хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм цуглуулж устгах орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 10-ныг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал амьтны сэг зэм устгал орчны халдваргүйтгэлийг мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон журам зааврын дагуу орон нутгийн байгууллага, иргэд, малчдын оролцоотой зохион байгуулж ажиллахыг 1,2,3,4,5 багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Сэг зэм устгасан талбай, мал, амьтан үхсэн хашаа, байр, худаг, уст цэг, гол, булаг шанд, бэлчээрийн орчныг халдваргүйтгэх ажлыг хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал, малын эмч Ч.Хоролмаа, О.Батболд, С.Сарантуяа нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр ханган, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Д.Баярмаа), байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа) нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д хариуцуулсугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2376910958

